Golomt Capital®
Delivering diversity

Interactive Brokers

# ТОЙМ



## ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

2024.07.29

*Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв*

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- Гайхамшигт 7 технологийн компаниудын зах зээлийн үнэлгээ нийтдээ 750 гаруй тэрбум ам.доллароор буурлаа.
- АНУ-д үл хөдлөхийн зах зээл буурч байгаа ч бизнесийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байна.
- АНУ-ын (PCE) үнийн индекс 6-р сард 0.2%-иар өссөн бөгөөд жилийн 2.6%-ийн өсөлттэй хэвээр байна.
- Хятадын Төв банкны хүүг гэнэт бууруулсан ч эдийн засгийн сэргэлтийн төлөвт итгэл төрүүлээгүй тул хувьцаанууд уналттай байлаа.
- БНХАУ-ын жижиглэнгийн худалдаа, аж үйлдвэрийн үйлдвэрлэл болон үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт буурсан нь эдийн засгийн удаашралыг илтгэж байна.
- Хятадын ардын банк 1 жилийн хугацаатай зээлийн үндсэн хүүг 10 суурь нэгжээр бууруулж 3.35% болголоо.

2024 он 7-р сарын 29

| | |
|---|---|
| Dow Jones | 40,589.34 |
| S&P 500 | 5,459.10 |
| Nasdaq | 17,357.88 |
| DAX | 18,417.55 |
| FTSE 100 | 8,285.71 |
| S&P/ASX 200 | 7,988.20 |
| HANG SENG | 17,211.10 |

### АНУ-ын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | 1.64% | 0.43% | 3.76% | 7.69% | 14.47% | 16.18% |
| S&P 500 | 1.11% | -1.89% | -0.03% | 14.45% | 19.14% | 24.20% |
| Nasdaq | 1.03% | -3.61% | -2.11% | 15.63% | 21.24% | 18.3% |

2024 оны 7 сарын 29-ний 11:00



### Европын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| DAX | 0.65% | 0.06% | 1.00% | 9.94% | 11.83% | 18.48% |
| FTSE 100 | 1.21% | 1.06% | 1.49% | 7.14% | 7.69% | 17.82% |

2024 оны 7 сарын 29-ний 11:00



### Ази Номхон далайн индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| S&P/ASX 200 | 0.84% | 0.68% | 2.81% | 5.21% | 7.87% | 8.03% |
| Hang Seng | 1.06% | -2.36% | -2.81% | 1.01% | -13.54% | -33.67% |

2024 оны 7 сарын 29-ний 11:00



# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**АНУ-ын зах зээл хоёр дахь долоо хоногтоо холимог гүйцэтгэлийг үзүүллээ**

- S&P 500 индекс нь долоо хоногийн эхэнд бага зэрэг өсөн ч 1.89 хувийн уналттай хаагдаад байгаа бөгөөд лхагва гарагийн арилжаагаар -2.31 хувиар унаж 2022 оны 12-р сараас хойш 1 өдрийн хамгийн муу гүйцэтгэлийг үзүүллээ.
- NASDAQ индекс мөн 3.61 хувийн уналтыг үзүүлж лхагва гарагийн арилжаагаар -3.64 хувиар унаж 2022 оны 10-р сараас хойш 1 өдрийн хамгийн муу гүйцэтгэлийг үзүүлээд байна.
- Харин DJIA индекс 0.43 хувийн бага зэргийн өсөлтийг үзүүлэн аж үйлдвэрлэлийн салбарын компаниудын 2-р улирлын тайлан сайн гарч өндөр гүйцэтгэлтэй байлаа.

Гайхамшигт 7 технологийн компаниудын зах зээлийн үнэлгээ нийтдээ 750 гаруй тэрбум ам.доллароор буурч, бүгд 2.5 аас дээш хувийн уналтыг 1 өдрийн дотор үзүүлээд байсан юм. Гэсэн ч, шинжээчид S&P 500-ийн нийт орлого өмнөх жилийн мөн үеэс 9.8%-иар өснө гэж таамаглаж байна.

**Үл хөдлөхийн зах зээлийн өсөлт удааширч байна**

Үл хөдлөхийн зах зээл буурч байгаа ч бизнесийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байна.

- **Шинэ орон сууцны борлуулалт**: 6-р сард 617,000 болсон ба хүлээлт 640,000 байсан
- **ҮХХ дундаж борлуулалтын үнэ**: Өмнөх жилээс 4%-иар буурсан
- **Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа**: S&P Global Index 49.5 болж буурсан. 50-с бага байвал уналттай гэж үздэг.
- **Бодит хэрэглээний зардал**: 2-р улиралд өмнөх оны мөн үеэс 2.3%-иар өссөн

**Хэрэглээний зардлын үнийн өсөлт 2.6% гарч зорилтот түвшинд ойртлоо**

Худалдааны яамны хүнс, эрчим хүчнээс бусад хувийн хэрэглээний зардлын (PCE) үнийн индекс 6-р сард 0.2%-иар өссөн бөгөөд жилийн 2.6%-ийн өсөлттэй хэвээр байна. Энэхүү инфляцын мэдээлэл нь 9-р сард ХНС хүүг бууруулна гэсэн хүлээлтийг илүү бататгаж өгсөн. Мөн энэ долоо хоногт пүрэв гарагийн 02:00 цагаас ХНС-аас бодлогын хүүгийн шийдвэрээ танилцуулах бөгөөд үүнтэй зэрэгцэн 7-р сарын ажилгүйдлийн түвшин болон үйлдвэрлэлийн үнийн индексийн мэдээнүүд тус тус зарлагдана.

**График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал**



# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

**Хятадын зах зээл дахин уналттай байлаа**

Төв банкны хүүг гэнэт бууруулсан ч эдийн засгийн төлөвт итгэл төрүүлээгүй тул хувьцаанууд уналттай байлаа.

- **Shanghai Composite Index**: 3.07% буурсан
- **CSI 300 (цэнхэр чипийн индекс)**: 3.67% буурсан
- **Hang Seng Index**: 2.28% буурсан

Хятадын Ардын Банк (PBOC) 2023 оны наймдугаар сараас хойших анхны удаагаа хүүгээ бууруулаад байгаа ба дэлгэрүүлээд үзвэл:

- Дунд хугацааны зээлийн хүүг 20 суурь нэгжээр бууруулж 2.3%
- Долоон өдрийн урвуу репо хүүг 10 суурь нэгжээр бууруулж 1.7%

Үүний дараа Хятадын банкнууд:

- Нэг жилийн зээлийн үндсэн хүүг 10 суурь нэгжээр бууруулж 3.35%
- Таван жилийн зээлийн үндсэн хүүг 10 суурь нэгжээр бууруулж 3.85%

Эдгээр хүү бууруулалтын алхмууд нь Хятадын ДНБ хоёрдугаар улиралд хүлээлтээс доогуур гарсны дараа эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой байв. Жижиглэнгийн худалдаа, аж үйлдвэрийн үйлдвэрлэл болон үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт буурсан нь эдийн засгийн удаашралыг харуулсан. Олон шинжээчид төв банк бодлогын хүүг үргэлжлүүлэн сулруулж, банкны заавал байлгах нөөцийн харьцааг бууруулна гэж хүлээж байна.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 оны 2 дугаар улиралд 4.7 хувь гарч, өсөлтийн хурд өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар саарлаа. 2024 оны 6 дугаар сард аж үйлдвэрийн гарц, жижиглэнгийн худалдааны өсөлтийн хурд саарч, инфляц өмнөх сараас буураад байсан юм.

### График 2: Hang-Seng индексийн ханшийн таамаг



# ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**




**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

